

ХИЛ СУДЛАЛ

Улсын хил хамгаалалт, халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх нь

Тодорхой тогтоогдон найдвартай хамгаалагдаж буй улсын хил бол газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хангах чухал нөхцөл болдог. Төр улсын тогтвортой хувьсал, өөрчлөлтийн өрнөл дунд үндсэний аюулгүй байдал, түүний дотор улсын хил хамгаалалтыг хангах сонгомол тогтолцоо аажмаар бүрэлдэн бий болж, боловсрон төгөлдөржиж байх учиртай, гэхдээ амьдрал байран дээрээ байгаад л байдаггүй болохоор өчигдөрхөн хөдөлбөргүй, маргаангүй мэт санагдаж байсан юмс өнөөдөр ач холбогдлоо алдах юмуу шинэ хэлбэрт шилжиж байна. Ялангуяа цагийн байдалд зохицуулан шуурхай шийдвэр гаргахыг шаарлдаг, хэцүү аюултай үед бол бүр хурдан өөрчлөлт гарна.

Дэлхий дахины геополитикийн хийгээд цэрэг улс төрийн байдал зарим улсын бодлогод зохих өөрчлөлтүүд гарч байна. Өчигдөрийн дайснууд наанаа хуурамч нөхөрсөг дүр үзүүлэвч цаанаа мэдээлэл, санхүү, эдийн засаг, үзэл суртал, соёлын талаар түрэмгийлэх, түрэмгийллийн шинэ хэлбэрт шилжиж эхэллээ. Энэ бүхэн улс орны хил хязгаарын аюулгүй байдлыг хангах тогтолцоог үүнд зохицуулахыг зүй ёсоор шаардаж байна.

Хил хамгаалалтын бүтэц зохион байгуулалт, удирдлага, хангалт, байршил, шийдвэрлэх үүргийг өөрчлөх ямарваа арга хэмжээнд зардал хөрөнгө шаардагддаг. Улс төрийн, батлан хамгаалалтын бусад зорилгоор, улсын хилийн хамгаалалт, халхлалтын тогтолцооны бүтэц, бүрэлдэхүүний нэр хаяг өөрчлөгдөхөд хүртэл зардал гаргах хэрэгтэй болдог.

Ингэхлээр нэг талаас шинэ нөхцөл, зорилт, хүчин зүйлүүд, нөгөө талаас санхүү эдийн засгийн хүндрэл, заримдаа нийгэм улс төрийн хязгаарлагдмал байдал төрийн өмнө тулгардаг. Төрийн ашиг сонирхол хөндөгдөшгүй байж, төр улс, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал тусгаар тогтнолоо хадгалах хил хязгаараа манах хэрэгцээ эх орноо хамгаалах эрхэм хүндтэй үүрэг хөдлөшгүй хэвээр үлдэнэ.

Янз бүрийн бүс нутгийн цаг улирал физик газарзүй эдийн засаг нийгмийн ялгавартай нөхцөл хил залгаа улсуудын улс төр цэрэг эдийн засаг соёлын зохих онцлогууд хил хязгаарын үндэсний аюулгүй байдлыг хангахад бүтэц бүрэлдэхүүн зэвсэглэлээрээ ялгаатай төрөл бүрийн хүч хэрэгслэлүүдийг татан оролцуулахыг шаардаж байна. Хилийн анги салбаруудын ерөнхий зорилго нэр хаяг нь өнгөн дээрээ адилхан юм шиг харагдавч зохион байгуулалт бүрэлдэхүүн тоо, зэвсэглэл удирдлага нь янз янз өвөрмөц байдаг.

Иймд улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог улс орны дотор болон хилийн чанадад гарч байгаа ба гарч болох өөрчлөлтөд зохицуулах шаардлага санхүү эдийн засгийн хязгаарлагдмал байдал хил хамгаалах байгууллагууд тэдгээрийн гүйцэтгэж байгаа үүргийн онцлогууд хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн хүч хэрэгслэлүүдийг тэнцвэржүүлэх асуудлыг судлах шаардлагатайг харуулж байна.

Тэнцвэржүүлэх асуудлыг хил хязгаарт, үндэсний аюулгүй байдалд учирч байгаа тодорхой хугацааны дараа учруулж болох аюулыг улс орны санхүү эдийн засгийн боломжид зохицуулан үр дүнтэй урьдчилан сэргийлэх таслан зогсоох чадвартай улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоо бүрдүүлэх явдал юм гэж тодорхойлж болох байна.

Уг асуудлыг шийдсэнээр хязгаар нутагт төрийн аюулгүй байдал ашиг сонирхолыг боломжийн хэмжээд халхлах чадвартай хүн хүч, зэвсэглэл, техникийн бодитойгоор бүрдүүлж чадах бүрэлдэхүүний тоо хэмжээ тодорхойлогдох ёстой.

Хил хамгаалах байгууллагын зэвсэглэл улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудал төрийн хилийн бодлогын чухал хэсэг бөгөөд буй болсон цэрэг улс төрийн нөхцөл байдалд үндэслэгдэн төр засгийн төвшинд шийдвэрлэгдэх учиртай. Гэхдээ хил хамгаалах байгууллагын дотоодод нарийвчилсан судалгаа явуулахгүйгээр тохирсон шийдвэр гаргах боломжгүй юм. Ийм учраас нөхцөл байдлыг судлаж дотоодын хэмжээнээс эхлэн асуудлыг шат шатанд нь дэс дараатай тохируулан шийдвэрлэх нь зүйтэй.

ХИЛ СУДЛАЛ

Хилийн аюулгүй байдлыг хангах зорилго түүнийг биелүүлэхэд оролцох байгууллагууд, шаардагдах хэрэгслэл, эрх үүргийн хувиарлалт төрийн төвшинд тодорхойлогдоно. Стратегийн чиглэл хилийн ангиудын төрөл тоо тус бүрийн хүч хэрэгслэлийн бүрэлдэхүүн байршил бүтэц зэвсэглэл нь хил хамгаалах байгууллагын төвшинд тодорхойлогдоно.

Улсын хилийн хамгаалалт халхлалтын тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд хөрөнгө хүч хэрэгслэлийн хуваарилалт хийхдээ тус орныхоо амьдрал ажиллагааны бараг бүх салбар хилийн хэсэг тус бүрийн онцлог, цэрэг, газар зүй, цаг улирлын нөхцөл бүгдийг харгалзах хэрэгтэй болдог. Хилийн анги, салбаруудыг зэвсэглэх, улсын хилийн хамгаалалт, халхлалтын тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд хөрөнгө мөнгөнөөс гадна, цаг хугацаа зарахыг шаардана. Иймээс гаргасан зардлаа нөхөхийн тулд, нарийвчилсан угтвар судалгаанд үндэслэж тэнцвэржүүлэх асуудлаа шийдвэрлэх хэрэгтэй. Хэд хэдэн жил, магадгүй хэдэн арван жилийн угтвар судалгаа энд шаардагдаж болно.

Ажиллах нөхцөл, гүйцэтгэх үүргийг нь тодорхойлж, улсын хилийн хамгаалалт халхлалтын тэнцвэржүүлсэн тогтолцоон дахь хүч хэрэгслэлүүд тэдгээрийг шийдвэрлэдэг болохоор зөвхөн өөрийн орны улс төр, эдийн засаг, цэргийн хөгжилтөөр хязгаарлахгүйгээр дэлхий нийт, юун түүрүүнд зэргэлдээх улсын цэрэг улс төрийн байдлыг урьдчилан судлах нь зүйтэй. Ингэж урьдчилан дүгнэхэд бэхршээлтэй байвал үйл явдлын өрнөлтийг хэд хэдэн хувилбараар, шаардлагатай бол тэднээс хамгийн магадлал ихтэйг нь сонгон судалж болох юм.

Судалгааны сүүлчийн шатны төгсгөлд энэ хугацаанд хил хязгаар, үндэсний аюулгүй байдалд учирч байгаа хийгээд учирч болох аюул тодорхойлогдох ёстой.

Монгол Улсын хил хязгаарт учирч болох аюул

Улсын хил, хязгаар нутагт төрийн (улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг, экологи, шинжлэх ухаан техник, соёл, мэдээлэл бусад)

ашиг сонирхол бүрэн хангагдсан байх нөхцөлийг Монгол улсын хил, хязгаарын аюулгүй байдал гэж ойлгоно.

Монгол улсын нутаг дэвсгэр өргөн уудам, хил залгаа улсуудын хамтын ажиллагаа, харилцаа холбоог харгалзан, хил хязгаарт оршиж буй аюулыг олж харах, сэрэмжлэн зайлуулах асуудал асар ач холбогдолтой юм. Ийм учраас зөвхөн хил хамгаалах үүргээ чанартай биелүүлээд зогсохгүй, эх орондоо учирч болох аюулыг дор бүр нь хэлж сануулахад хил хамгаалах байгууллагын ажиллагаа энэ асуудлыг шийдвэрлэхэд нэн чухал үүрэгтэй.

Төр нь нийгэм, хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэглүүр, хангах баталгаа байдаг бөгөөд төрийн ашиг сонирхол улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг, шинжлэх ухаан техник, экологи, соёл мэдээллийн гэж ангилагдана.

Аюул бас эх үүсвэрийнхээ төрлөөр ангилагдана:

- Дотоодын болон гадаадын (анхныхад нь аюулын эх үүсвэр дотооддоо байхад хоёр дахид нь гадаад талд байна).
- Бодит хөгжлийн явцад үүссэн аюул (эдийн засгийн хөгжлийн жигд бус байдал, байгалийн нөөцийг муутгах, хүрэлэн байгаа орчинг бохирдуулах гэх мэт).
- Нийгмийн тодорхой үйлдлүүдээр үүсгэгдсэн аюул (дайсны хорлон сүйтгэх ажиллагаа, лидерүдийн хувийн сонирхол, үндсэрхэх үзэл, шашны мөргөлдөөн, гэмт явдалд автагдах гэх мэт).

Бусад улсуудын нэ адил Монгол улсын хил хязгаарын ашиг сонирхол геополитикийн бодит боломж, дэлхий нийт, бүс нутаг, олон улсын харилцааны системд эзэлсэн байр суурь, гүйцэтгэж байгаа үүргээрээ тодорхойлогдоно.

Аль нэг ашиг сонирхлын хамгаалалтын зэргийг хоёр янзын тодорхой шалгуураар тодорхойлдог.

А. Хохирлоос сэргийлэх түвшин (жишээ нь улс орны байгалийн нөөцүүн барагдуулах, гол нуурын био нөөцийг хулгайлахаас хамгаалах гэх мэт)

ХИЛ СУДЛАЛ

Б. Аюулын түвшинг багасгах (Монгол улсын хувьд тааламжгүй бодит хүчин зүйлүүдийг багасгах жишээ нь олон улсын хурцадмал байдал, төрийн түшмэдүүд авилгалд автах, үндэстэн хоорондын сөргөлдөөн гэх мэт)

Монгол улсын ашиг сонирхол нь:

- Монгол улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн бие даасан байдлыг хамгаалах;
- Хөрш зэргэлдээ улсуудтай улс төр, эдийн засаг, цэрэг улс төрийн нягт хамтын ажиллагаатай байх;
- Ард түмний аж амьдралын өсөлт, нийгэм улс төр, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах;
- Төрийн байгуулалтыг боловсронгуй болгож, улс орныг тогтвортой үр нөлөөтэй удирдлагаар хангах;
- Хууль эрх, төрийн байгууллалыг хамгаалах;
- Нөхөрлөл, хамтын ажиллагаанд тулгуурласан олон улсын харилцаа холбоо тогтоон хөгжүүлэх, үр ашигтай дотод, гадаад бодлого явуулах;
- Гадны аюулаас өөрийгөө хамгаалах чадвартай байх;
- Зэргэлдээх улсын цэргийн чадавхи хил, хязгаарыг аюулаас хамгаалахад хамтран ажиллах зэрэг болно.

Монгол улсын хил хязгаар, төрийн ашиг сонирхолд учирч болох гол аюулууд гэвэл:

- Тусгай албадын тагнуулын үйл ажиллагаа;
- Зэргэлдээх улсын эдийн засаг, хүн амын түрэлт;
- Контрбандын үйл ажиллагаа идэвхижих, үндэсний баялагийг хулгайлан шамшигдуулах;
- Мөнгөн хөрөнгө, стратегийн чухал түүхий эдийн нөөцийг гадагш зөөх;
- Хүн амын амьдралын түвшин буурч, сөргөлдөөн үүссэнээс байдал тогтворгүй болох;
- Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм;
- Зэвсэг, байлдааны зориулалттай бусад хэрэгсэл цугларах тархах;
- Хил дамнасан тархах эвдрэл, сүйрэл, байгалийн гамшиг хүрээлэн байгаа орчны бохирдол зэрэг болно.

Эдгээрээс:

А. Улс төрийн аюул:

- Газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хадгалах, дотоод бодлого явуулахад Монгол Улсын тусгаар тогтнолыг алдагдуулах;
- Эдийн засгийн талаар хүчирхэг гүрнүүдийн талаас улсын хилийн хууль, хил, гааль бусад хяналтуудыг алдагдуулснаар аажим эзэмших;
- Улсын хил, хязгаар нутагт үндэсний ашиг сонирхлыг хохироох;
- Монгол улсын газар нутагт өнгөлзөх;

Б. Цэргийн аюул:

- Монгол улсын ашиг сонирхлыг хамгаалж байгаа хүчний сулралаас болоод бүс нутгийн хамгаалалт, халхлалт муудах, зэвсэглэл хуучирч, хангалт тасалдах;
- Монгол улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, салбаруудын байлдах чадвар муудах;
- Стратегийн нөөц барагдах;
- Хилийн хамгаалалт, халхлалт сулрах;
- Зэргэлдээх улсаас бүс нутгийн газар нутагт цэргийн тагнуул хийх боломж өргөжих;

В. Эдийн засгийн аюул:

- Төр засгийн зүгээс бүс нутгийн амьдрал, үйл ажиллагаа, хөгжил, дэвшлийг хяналтаасаа алдах;
- Зэргэлдээх улсын худалдаа, эдийн засаг, нөөц олзворлолтын эргэлтээс Монгол Улсыг болон түүний компаниудыг шахах эрмэлзлэл, эдийн засгийн түрэмгийлэл;
- Гадаад түншүүд Монгол улсыг аажимдаа тэдний технологи, бүтээгдэхүүний импортоос бүрэн хамааралтай түхий эдийн хавсарга болгох, эдийн засгийн гадаад харилцааны тогтолцоо бүрдүүлэх;
- Байгалийн баялагийг эзэмших салбарт, эдийн засгийн ашигтай төсөл хэрэгжүүлэх замаар Монгол улсаас өрсөх;
- Хил зөрчсөн ан агнуурын ажиллагааг бүрэн хянаж чалахгүй байх;

ХИЛ СУДЛАЛ

Г. Нийгэм, экологи, соёлын аюул

- Улс төр, үзэл суртлын сөргөлдөөн, хүн амын амьжиргааны ядуу байдлаас болсон нийгмийн ба нийгэм улс төрийн сөргөлдөөн үүсэх;
- Төрийн зүгээс иргэд, цэргийн албан хаагчдаа нийгэм, эрх, эдийн засгийн талаар муу хамгаалах;
- Залуучуудын сургуулийн болон техник, мэргэжлийн боловсролын тогтолцоо алдагдах;
- Хүн амаа байгалийн гамшгаас муу хамгаалах;
- Нийгэм, анги давхрагын хуваагдал гүнзгийрэх;
- Ажилгүйдэл өсөн, нийгмийн экстремизм тархах;
- Орон нутгийн засаг захиргаа гэмт явдалд автах;
- Нутгийн гүн рүү шилжих хөдөлгөөн ихсэх;
- Хүн амын нийгмийн идэвхи буурах;
- Эрүүл мэнд, боловсрол, тэтгэвэр, хөдөлмөрийн хөлс, хүнс барааны хангалт зэрэг нийгмийн баталгаа хөнгөлөлтийн систем алдагдах;
- Ашигт малтмал олзворлогч компаниудын ажиллагаанаас хилийн голууд бохирдох;

Д. Шинжлэх ухаан техникийн аюул

- Орон нутгийн шинжлэх ухааны байгууллага, судалгааны цогцолбор ажиллахаа болих;
- Үйлдвэрийн газруудад технологийн сахилга зөрчигдөх, тоног төхөөрөмж нь эвдэрч элэгдэх;
- Оюуны нөөц хомсдож, “тархитай хүмүүс” – ээ тарааж дуусах;

Е. Мэдээллийн аюул:

- Холбооны сувгуудын техникийн сул хамгаалал;
- Телевиз, радио, мэдээллийн бусад хэрэгслэлээр хүн амын оюун санаа, ёс суртахууныг зэрэмдэглэх, үндсэрхэг үзлийг дэвэргэх, хувиа бодсон, эрээ цээргүй, энэрэхийг мэддэггүй, гаж урлаг соёлыг бурханчлагч болгохоор явуулж байгаа мэдээллийн нөлөөлөл;
- Үндэсний үнэт зүйлс, соёл, Монгол улсын ашиг сонирхолд нийцсэн мэдээллийн бодлого дутагдаж байгаа эдгээр болно.

Төр засгийн хэмжээний үр дүнтэй хилийн бодлого, хил хязгаарын доторхи хямралт үзэгдлүүдийг даван туулах арга

хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлсээр байгаа болон үүсэж болох аюулуудын ихэнхийг арилган зайлуулж таслан зогсоож чадах болно.

Үүний тулд ямар аюул хаанаас учрахыг сайн мэдэж, сайтар задлан шинжлэх, өөрөөр хэлбэл хил хязгаарыг хяналтандаа байлгах, улсын хилийн хамгаалалт, халхлалтын тэнцвэржүүлсэн тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Улсын хилийн хамгаалалт, халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудалд хандах ерөнхий хандлага

Эдийн засаг, цэрэг, нийгэм, үйлдвэрлэл бусад байгууллын тэнцвэржүүлэлтийн асуудал дээр үеэс л төр засгийн түвшинд шийдэгдэж ирсэн. Хэвийн ажилладаг аль ч засгийн газар хэзээд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ улсаас төлөх өр, алт валютын нөөцөө голлон тооцож түүгээрээ хязгаарлан тэнцвэржүүлсэн улсын төсөв зохиохыг бодох нь зүй. Төсөв зохиоход дэлхийн болоод улс орны эдийн засгийн хөгжилт, зах зээл, цэрэг улс төр, хүн амын байдал, бусад олон хүчин зүйлүүдийг урьдчилан дүгнэж заавал харгалзан үзэх хэрэгтэй болно.

Энэ нь цэргийн салбарт төр улсын ашиг сонирхол, болзошгүй аюулын хэмжээгээр тодорхойлогдон, тэдний хангалт, дэд бүтэц, тоо удирдлагын систем, байршил, зохион байгуулалт, бусад асуудлуудыг хамарна.

Улс орны үндэсний эрх ашгийг хамгаалах чадвартай тэнцвэржсэн тогтолцоо бүрдүүлэх асуудал урьдчилсан судалгаа шаарддаг ихээхэн нарийн асуудал. Хил судлалын салбарт зарим нэгэн элемент нь судлагдаж байсан ч гэсэн улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудал урьд нь ингэж шулуун томъёологдож байсангүй.

Улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцооны үндсэн үүрэг, зорилтуудыг тодорхойлж өгдөг, Үндсэн хууль, бусад хуулиуд, цэргийн номлолуудад тусгалаа олсон төр улсын ашиг сонирхлыг үндэс болгох нь зүйтэй.

ХИЛ СУДЛАЛ

Энэ асуудлыг төрийн болоод байгууллагын гэсэн хоёр түвшинд шийдвэрлэх учиртай.

Төрийн хэмжээнд хийгдэх судалгааны ажлын үр дүн нь Үндсэн хууль, бусад эрхийн актуудад тусгалаа олж, улсын хилийн хамгаалалт халхлалтад хамааралтай яам газрууд тэдгээрийн үүргийг тодорхойлно.

Төр улсын хуулиудыг боловсруулагчид, нийгмийн өнөөгийн болон маргаашийн байгуулал, амьдрал ажиллагааг тодорхойлохдоо улсын хилийн хамгаалалт, халхлалтыг хариуцдаг яам, газруудыг байлгах, тэдгээрийг хөгжүүлэхэд хэрэгцээтэй төсөв хөрөнгө, засгийн газарт захиран зарцуулах боломж олгох, улс төр, эдийн засаг, санхүү, нийгэм, хүн ам, үзэл суртал, соёл бусад төр улсын түвшний хүчин зүйлүүдийг үндэс болгоно.

Ингэхдээ улсын хилийг хамгаалах халхлах зайлшгүй үүрэг хүлээсэн төрийн бүтэц (жишээ нь Хилийн цэрэг) –ийн хувьд энэ нь “шууд зориулагдсан” зардал болно.

Хилийн анги, салбаруудтай харилцан ажиллах тэдэнд тусламж үзүүлэхэд зориулж цагдаагийн байгууллага ариун цэврийн алба, тагнуулын байгууллага, зэвсэгт хүчинд гаргаж байгаа төсөв хөрөнгө эдгээр яам газруудад төсөвлөгдсөн үндсэн зардлын харьцангуй бага хэсэг байдаг тул төсөвт тусгайлан заадаггүй.

Хилийн аюулгүй байдлыг хариуцан хангуулах төрийн бүтэц, тэдгээрийн үүргийг тодорхойлох, улсын хилийн хамгаалал, халхлалтад шаардагдах хөрөнгө гаргах асуудлыг шийдвэрлэх бүртээ зэргэлдээх улсуудын гадаад бодлого, тэдгээрийн дотоод улс төр, нийгэм эдийн засгийн байдал цэргийн байгуулал зэрэг гадаад хүчин зүйлүүдийг харгалзаж үзэх ёстой.

Дотоод болоод гадаад олон хүчин зүйлийн нөлөөллөөр хязгаар нутгийн үндэсний аюулгүй байдалд аюул учирах нь мэдээж.

Үндэсний аюулгүй байдлын асуудал төрийн түвшинд шийдэгдэх үед улс орны тусгаар тогтнол газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хариуцдаг төрийн байгууллагууд гадаад дотоод хүчин

зүйлүүдийн сөрөг хандлагыг цаг тухайд нь илрүүлж болзошгүй үр дагаварыг урьдчилан тооцоолж байх учиртай.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргийг шууд гүйцэтгэдгийнхээ хувьд улсын хил хамгаалах байгууллага дотоод гадаад байдлын талаархи мэдээг тасралтгүй цуглуулж системчлэн тэдгээрээ дүгнэн шинжиж учирч байгаа аюулыг илрүүлээд зогсохгүй учрах аюулыг таслан зогсооход бэлэн байх чадвартай байх ёстой.


Эдгээр үнэлэлт урьдчилсан дүгнэлтүүдэд сонгосон чиглэл заагдсан хугацаанд улсын хил хамгаалах байгууллагуудаас хилийн аюулгүй байдлыг хангах үүргээ бүрэн дүүрэн биелүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийн хэмжээг тодорхойлоход ашиглагдана. Үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулж болохуйцаар гадаад дотоод байдал өөрчлөгдөх үед улсын хил хамгаалах байгууллага цагийн байдлын дүн шинжилгээнд тулгуурлан улсын хилийн хамгаалалт халхлалтыг хүч нэмэгдүүлэхээр бусад яамд газраас хүч хэрэгсэл хөрөнгө материалын нөөц нэмж гаргах юм уу үүргийг өөрчлөх асуудлыг хууль тогтоох байгууллага засгийн газрын түвшинд үндэслэгээ судалгаатай тавьж болно.

Улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудлыг судалгааны аргын талаас нь авч үзвэл уг асуудлаар улсын хил хамгаалах байгууллагын түвшинд юу хийвэл зохилтой вэ.

Улсын хил хамгаалах байгууллагын түвшинд хилийн анги салбаруудын бүрэлдэхүүн тэдний хариуцах хэсэг, бүтэц, тоо, байршил, удирдлага зохион байгуулалт хангалт бүрдэл зэвсэглэл улсын хилийн хэсэг шалган нэвтрүүлэх байруудын төхөөрөмжлөлийг үндэслэхэд чиглэгдсэн судалгаанууд хийгдэнэ. Өөрөөр хэлбэл УХХБ-ын үүрэг зорилгоос урган гарах улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудлыг өөрийн түвшинд шийднэ.

Гэхдээ улсын хилийн аюулгүй байдлын гадаад аюулын хэмжээ хамаарлыг үнэлэхийн зэрэгцээ өөрийн талдаа үүсээд байгаа аюул сөрөг хандлагыг илрүүлэх зорилгоор хязгаар нутагт болж байгаа үйл явцыг ч адилхан үнэлэх хэрэгтэй.

ХИЛ СУДЛАЛ



Дотоод болоод гадаад аюул хилийн албан хилийн анги салбаруудын байдлыг урьдчилсан үнэлгээнд тулгуурлан хилийн хамгаалалт халхлалтыг тэнцвэржүүлсэн тогтолцоо үндэслэгдэнэ.

Ингэхэд улсын хөрөнгө хязгаарлагч (сахилгажуулагч) нөхцөл болон гарч ирэх боловч судалгааныхаа явцад тэнцвэржүүлсэн тогтолцоо буй болгоход гаргаж байгаа хөрөнгийн хэмжээ хэлбэлзэж болох “завсрыг” тодорхойлох нь зүйтэй.

Дээд хязгаар нь хөрөнгө гаргаснаар судлагдах хугацаанд аюулаас урьдчилан сэргийлэх, үүссэний аюулыг зайлуулах, (саармагжуулах) хил хязгаарыг бодит аюулгүй байлгах эсвэл аюулын голомтыг бага дээр нь дарахад хүрэлцэх хэмжээг заах бөгөөд тогтолцооны энэ байдлыг бүрэн тэнцвэржүүлсэн гэж үзнэ.

Улсын эдийн засгийн бодит боломж тухайн нөхцөлд хязгаарлагдмал байж болохыг харгалзан судалгааныхаа явцад улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоо аюулгүй байдлын дотоод гадаад аюултай бүрэн тэнцвэржиж чадахгүй юм аа гэхэд ядахдаа төр улсын тусгаар тогтнол газар нутгийн бүрэн бүтэн байдалд учирч буй аюулыг эхний ээлжинд зайлуулах боломжтой хөрөнгийн хамгийн багаар шаардагдах хэмжээг тодорхойлно.

Гаргаж байгаа хөрөнгийн хамгийн багаар шаардагдах хэмжээ нь багассанаар хил хязгаараа хяналтаасаа алдаж хүнд хортой үр дагаварт хүргэнэ.

Энэ хэмжээ бол тэр хязгаараас доошлох аваас улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоо хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэх тийм зааг юм.

Иймд улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудлыг шийдвэрлэхэд хилийн аюулгүй байдалд учрах аюулыг илрүүлэн үнэлэх арга боловсруулахтай холбогдсон судалгаа онцгой байр эзлэнэ.

Хязгаар нутагт үндэсний аюулгүй байдалд учрах аюулын хэмжээг үнэлэх нь

2000 он солилцох зааг дээр сэргөлдөн тэмцэгч хүчний үйл ажиллагааны нөлөөллөөр зарим улсын тусгаар тогтнол газар нутгийн бүрэн бүтэн байдал ноцтой аюул учрах шахав.

Энэ нь олон эрдэмтэд шударга улс төрчдийг улс төр, цэрэг, эдийн засаг, мэдээлэл, шинжлэх ухаан, соёл боловсрол гэх мэт амьдрал үйл ажиллагааны бусад салбарт үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалд анхаарлаа хандуулахад хүргэлээ.

Гэхдээ зарим суурь судалгааг сайн хийж байгаа ч аюулгүй байдлын ерөнхий онол боловсроогүй л байна. Энэ нь аюулгүй байдлыг өөрийнхөөрөө тайлбарлах гэдэг буруу ойлголтоос салах олон янзын төрөл салбарын мэдлэгийг нийлүүлэн цогц болгох шаардлагатайгаар тайлбарлагдаж байгаа юм.

Үндэсний аюулгүй байдал (тэр дундаа хил хязгаарийн) тодорхой асуудлыг тодорхойгүй нөхцөлд заримдаа зарим удирдагчид бүлэг хүмүүсийн дайсагнасан үйл ажиллагаа мөргөлдөөнт байдалд шийдвэрлэх хэрэгтэй болдог.

Зэргэлдээх улс нийгмийн субъектүүдийн ашиг сонирхол үйл ажиллагааны зөрчилдөөн бусад субъектүүддээ аюул учруулж болох юм.

Салингид асуудлууд тун олон бас нарийн учир тэдгээрийг хурдан хугацаанд бүрэн судалж нэгтгэх боломж муутайгаас төрөл бүрийн салбарын үйл ажиллагааны судлагааний үр дүнг цогц болгох замаар аюулгүй байдлын ерөнхий онол ойрын үед боловсруулна гэдэг нэн төвөгтөй.

Гэсэн хэдий боловч улс төр, батлан хамгаалах, эдийн засаг, боловсрол, санхүү бусад салбаруудын үйл ажиллагааны аюулгүй байдлын асуудлаар ажиллаж байгаа судлаачид аюулгүй байдлын ерөнхий онол түүний зарим хавсарга чиглэлд хэрэглэж болох санаануудаараа нэгдсэн ойлголтод хүрэх зарчим баримтлах нь зүйтэй.

ХИЛ СУДЛАЛ

Гол санааг нь бусад салбарын адил асуудлуудыг шийдвэрлэхэд хэрэглэж болох төрийн хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюулын хэмжээг үнэлэх аргачлалыг боловсруулахдаа улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоог тэнцвэржүүлэх асуудлыг шийдвэрлэхийн тулд аюул үүсэх боломж үүсээд байгаа аюулын хэмжээг үнэлэх нь зайлшгүй гэдгийг үндэс болгож байгаа юм.

Зарим хүчин зүйлүүдийн тохиолдлын өрөөсгөл шинж хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоонд нөлөөлж буй бодит аюулын хэмжээний талаар мэдээлэл дутмаг байх нь аюул үүсэх ихсэх явцын хэлбэржүүлсэн аналитик загвар боловсруулах тэнд хүрэхээрээ тогтолцооны байдлыг чанрын хувьд сөрөг өөрчилдөг. Тэр заагийн зарим утгыг гаргаж аюулын хэмжээг тоогоор үнэлэхэд саад учруулдаг.

Энэ бүхэн аюулгүй байдлын асуудлаар суурь шийдэл гаргах үед тодорхой шинжлэх ухааны боловсорсон аргыг бүрэн ашиглах боломжийг ихээхэн хязгаарладаг.

Гэсэн хэдий ч энэ математик, статистик операцийн шинжилгээ урьдчилан дүгнэх шийдвэрээ үндэслэж гаргах болон мөргөлдөөн сүйрлийн онолууд өөрөөр хэлбэл загварчилах урьдчилан дүгнэх математик аргуудыг хэрэглэхээс татгалзах хэрэгтэй гэсэн үг биш ээ.

Хил судлал аюулгүй байдлын ерөнхий онолын нэгэн адил зөвхөн судлагдан буй асуудалд тоон дүгнэлт гаргаж тайлбар өгөөд зогсохгүй үйл явцын болзошгүй өрнөлтийг түрүүлэн харж ямарваа нөхцөлд үүсэх аюулын хэмжээг тогтоож үнэлэлт өгөх, өөрөөр хэлбэл тоон шинжилгээ хийж урьдчилан дүгнэх аргыг боловсруулж өгдөг.

Хязгаар нутагт гарч болзошгүй үйл явцын сөрөг өрнөлтийг хянах, урьдчилан дүгнэх чадвартай улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоо аль хэдий нь үүсэх аюулыг илрүүлэх боломжтой. Тогтолцооноосоо ямагт үр дүнтэй давуу талтай гэдэг нь хэнд ч тодорхой. Түүний сацуу аюулаас урьдчилан сэргийлэх (гаргуулахгүй байх) шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүссэн аюулыг зайлуулахаас ихээхэн хямд төсөр байдаг.

Өөрөөр хэлбэл хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн тогтолцоо нөхцөл байдлын болзошгүй сөрөг өрнөлтийг урьдчилан тооцох зарчимд үндэслэгдэх ёстой.

Хязгаар нутагт үндэсний аюулгүй байдал учирсан аюул яхаж бий болох, ямар хэмжээнд хүрэхийг үнэлэх асуудлыг шийдвэрлэх дараалалд доорх арга хэмжээнүүдийг хамааруулна.

- Тогтолцооны хэмжүүрийг тогтоох

- Хэмжүүрийн тус бүрийн байдлын шууд ба шууд бус үзүүлэлтүүдийг үндэслэж бүртгэх

- Үзүүлэлт нэг бүрээр аюул авчирч болзошгүй хандлага байгаа шууд болоод шууд бус шинж тэмдэгүүдийг тогтоох

- Аюулгүй байдлын болон давуулж болохгүй нэгдсэн босгууд үзүүлэлтүүдийн жингийн коэффициентүүдийг тодорхойлох болно.

Энэ асуудлуудыг шийдэхийн тулд нөхцөл байдлыг тогтмол судлан шинжилж үзүүлэлтүүдийн утгыг үе үе үнэлэн үзэж тэдгээрийг босгуудтай харьцуулан дүгнэж урт удаан хугацааны туршид хийсэн үнэлэлтүүдээ улсын хилийн тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд хэрэгтэй хөрөнгийг шаардагдах хэмжэг үндэслэхэд хэрэглэа ба урсгал (үе үе) хийгддэг үнэлгээг аюулаас урьдчилан сэргийлэх тэдгээрийг зайлуулах арга хэмжээний тогтолцоо боловсруулахад ашиглана.

Хилийн аюулгүй байдалд гадны ямар аюул учирч болох нь зэргэлдээх улсуудын бодлого тэдгээрийн дотоод байдлаар тодорхойлогддог улс орны эрүүгийн болоод олон нийт гүйцэтгэх засаглалын байгууллагуудад шургалсан янз бүрийн тогтворгүй байдал үүсгч хүчнүүдийн нөлөөллөөр хилийн аюулгүй байдалд дотоодоос заналхийлж болно. Иймэрхүү тааламжгүй нөхөл байдал дотоодод бий болох нь хил хязгаарт тогтворгүй байдал үүсгэж энэ нь нийгэм, эдийн засаг, угсаатан, байгаль орчин, эрүүгийн нөхцөлд байдалд тогтворгүй улсуудтай хиллэгддэг хил дээр бүр ч хурц илэрдэг.

Энэ бүгд хилийн юулгүй байдалд далдуур заналхийлж байгаа юм, үүссэн аюулыг үнэлэхэд бүсчилж хандах нь зүйтэйг харуулж байна. Эдгээр чиглэлүүдийн тоо голдуу хил залгаа улсуудын тоогоор тодорхойлогдох боловч физик газарзүйн нөөц баялаг,

ХИЛ СУДЛАЛ

улирал, ус цаг уур, бусад нөхцлүүдийг харгалзан үзнэ. Хил хамгаалалтын анги салбаруудын хүч хэрэгслийг тэнцвэржүүлсэн бүрдлийг үндэслэж гаргахдаа эдгээр бүсүүд (чиглэлүүдийн) онцлогийг тооцох учиртай нь эндээс тодорхой байна.

Хилийн анги салбаруудын хүч хэрэгслэлүүдийг тэнцвэржүүлэх асуудлуудын дараа дараагийн шийдэл ямар байх нь эдгээр үнэлгээнүүдийн үнэн зөвөөс үндсэндээ шалтгаална. Иймд аюулын хэмжээг үнэлэх талаар шаардлагатай бүх мэдээлийг цуглуулан нэгтгэж нарийвчлан судлах хэрэгтэй. Хилийн цэргийн мэдээлэл шинжилгээний албад энэ асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцоно.

Улсын хилийн хамгаалалт халхлалтын тогтолцоо бүрдүүлэх талаар дээр бичсэнчлэн сонгон судалсан хугацааны урьдчилсан үнэлгээндээ үндэслэн тэр хугацаандаа тохирсон хүч хэрэгслэлийн тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлнэ. Аливаа урьдчилсан үнэлгээ магадлалын тодорхой зэрэглэлтэй улсын эдийн засгийн боломж янз бүр байхыг бодолцон хил хамгаалалтын хүч хэрэгслийн тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд зайлшгүй шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох хэрэгтэй.

Бүрэн тэнцвэржсэн юм уу багаар гаргаж чадах хөрөнгийн хэмжээний үндэслэл алив аюулыг бүрэн зайлуулах юм уу үгүйдээ эс зайлуулах аваас сүйрэлд хүргэх тэр аюулыг арилгаж чадахуйц байх шаардлагад захирагдах ёстой. Зөвшөөрөгдөх “завсар”-ын ямар байх нь ч энэгшаардлагаар тодорхойлогдоно.

Улсын хилийн хамгаалалт халхлалтын туршлага, оперативийн урлаг, тактикийн шаардлагад үндэслэн авч хэрэгжүүлснээр ямар аюулаас хэдий тооны хүч хэрэгслэлээр хамгаалж болох арга хэмжээнүүдийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг гаргаж болно.

Хязгаар нутагт цагийн байдал ихээхэн муудваас бүр ганц биш хэд хэдэн ноцтой аюул тулгарч болох юм. Ийм учраас эдгээрийг саармагжуулах хүч хэрэгслэлийн бүрдлийн тооцоо, тулгарсан аюулыг арилгахад хил хамгаалах байгууллагын хүч хэрэгслэлүүдийн зэрэгцсэн ажиллагаа нэлээд төвөгтэй хувилбараар хийгдэх учиртай.

Тайван цагт хилийн аюулгүй байдалд учирч буй аюулд дайсны талаас мэдээллийн, тагнуулын хорлон сүйтгэх ажиллагаа гэхчилэн тусгай операцууд бэлтгэж явуулах аюулууд нэмэгдсэнээр нэг юм уу хэд хэдэн стартегийн чиглэлүүдэд нэн аюултай нөхцөл байдлууд үүсэж болох юм.

Тайван цагийн ба аюул учирсан үеийн энэ бүх аюулыг арилгах чавартай хил хамгаалах байгууллагын хүч хэрэгслэлийн бүрэлдэхүүн, хилийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах хөрөнгийн дээд хэмжээг тодорхойлно.

Хүч хэрэгслийн бүрэлдэхүүнийг бодохдоо тэдгээрийн тоо, зэвсэглэл төдийгүй зохион байгуулалт, байршил удирдлага бүхий бүтцийг нэг мөсөн тооцоолох хэрэгтэй. Гэхдээ нэг л аюул бүх чиглэлээс ирнэ гээд байх биш, бүсчлэх зарчмыг хатуу баримтлах нь зүйтэй.

Эцэст нь улсын хилийн хамгаалалт, халхлалтын бүрэн тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн нийт хэмжээг гаргана. Шаардагдах хөрөнгийг бүрэн хэмжээгээр нь гаргаж өгсөн нөхцөлд энэ хөрөнгөөр бүрдүүлсэн улсын хилийн хамгаалалт, халхлалт болзошгүй аюулыг сөрөн зогсох чадвартай болно.

Тэнцвэржүүлсэн тогтолцоог бүрдүүлэхийн тулд шинжлэх ухаан, зохион байгуулалт, техникийн чанартай олон тооны асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй болно. Үүнд шинэ нисдэг тэрэг, хил хамгаалалтын техник хэрэгслэлүүд, инженерийн төхөөрөмж, зэвсэг техник худалдан авах, анги салбаруудыг шинээр байгуулах, барилга байгууламж барих гэхчилэн олон арга хэмжээнүүд хамаарч байгаа юм.

Ийм учраас улсын хилийн хамгаалалт, халхлалтын тэнцвэржүүлсэн тогтолцоог бүрдүүлэх (өөрчлөн шинэчлэх) төлөвлөгөө гаргах нь зүйтэй. Энэ бол ихээхэн төвөгтэй төр засгийн томоохон зорилт.

Хэрэв улс судлагдан буй хугацаанд тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд шаардагдах хэмжээний хөрөнгийг гаргаж өгч чадахгүй, төсвийн төлөвлөгөөнд хасагдаж тусгагдвал, хилийн

ХИЛ СУДЛАЛ

цэргийн удирдлага, хязгаар нутагт ноцтой уршиг учруулж мэдэх тэдгээр аюулуудыг түрүүнд зайлуулахад ийм хэмжээний хөрөнгө хүрэлцэх үү гэдэгт үнэлэлт өгөхөд бэлэн байх хэрэгтэй.

Үүний тулд тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээтэйгээ хамтатгаад, хасаж танаж болохгүй хамгийн бага түвшнийг тодорхойлоно. Энэ түвшин, тогтолцоо хүлэсэн үүргээ амжилттай биелүүлэхэд, заагт нь барьж байвал зохих тэрхүү “завсар”-ын доод хязгаар юм.

Дүгнэлт болгоход

- Төрийн ашиг сонирхол гэдэг бол нийгэм хувь хүмүүсийн амин чухал ашиг сонирхлын хураангуйлсан илэрхийлэл юм. Эдгээр нь хязгаар нутагт илрэлээ олж төрийн хилийн бодлого боловсруулах үндэс болдог.

- Олон улсын байдал, ялангуяа Монгол улсын өөрийн гадаад болон дотоод улс төрийн байдал, төрийн аюулгүй байдалд занал учруулж, тэдгээр нь хил хязгаарын дотор илрэн бүс нутгийн, бүр цаашлаад төр улсын хэмжээнд хүрэх сөрөг хандлагын өвөрмөц заагуурын үүрэг гүйэтгэдэг.

- Аюулуудыг судлан дүгнэхдээ юун түрүүнд байгаа мэдээллээ боловсруулах, төр нийгэм, иргэдийн үйл ажиллагаа (улс төр цэрэг эдийн засагтэх мэт) - ны бүх хүрээлэл дэх зөрчилдөөний харьцуулан шинжлэх, Монгол улсын хил хязгаарын ашиг сонирхолд харшлах аюулыг ангилан бүлэглэж гаргах нь зүйтэй. Аюулыг тодорхойлох зөрчилдөөний харьцуулан дүгнэх хангалттай мэдээлэл байхгүй бол шинжлэх ухааны үндэстэй өөр аргуудыг хэрэглэж болох юм.

- Аюулууд тодорхой сонирхолтой холбоотой байдгаас тэдгээрийг зэрэглэхийн тулд аюул бүрийн хэмжээ, холбогдол, гарах шалтгааныг мэдэж байх нь чухал.

- Байгаа болон бий болж болох аюулууд, тэдгээрийг зайлуулах таслан зогсооход шаардагдах арга хэмжээнүүд улсын хилийн хамгаалалт, халхлалтын тэнцвэржүүлсэн тогтолцоо бүрдүүлэх анхны өгөгдөхүүн болох ёстой.

Докторнат дэд хурандаа Д.Нямдорж